



ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 0106

Жаргалтхаан сум

Д.Мөнхбаярыг туршилтын хугацаагаар томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 50 дугаар зүйлийн 50.1.2, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралт, “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын нярав Ганболдын Жавзанжамъян нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул уг албан тушаалд Дашнямын Мөнхбаярыг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн туршилтын хугацаагар түр томилсугай.

2. Хөдөлмөрийн гэрээ болон албан тушаалын тодорхойлолтонд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж ажиллахыг Д.Мөнхбаярт үүрэг болгосугай.

3. Нярав Д.Мөнхбаярын үндсэн цалинг TY-4 дэх шатлал 1,105,000 (нэг сая нэг зуун таван мянган) төгрөг, орон нутагт ажилласны нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар тооцож цалинжуулахыг нягтлан бодогч Э.Загдхүүд зөвшөөрсүгэй.

ДАРГА

С.МӨНХДЭЛГЭР

